

Хотжилт, цаг уурын дулаарал ба халдварт өвчин

*Зоригоо Б., Сувд Д.
Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн*

Танилцуулга

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд болон монгол улсад агаарын температурын өсөлтөөс үүдсэн халдварт өвчний тархалт нэмэгдэх хандлагатай байна. Монгол улс 1940-1975 оныг хүртэл 10 жил тутам $0,06^{\circ}\text{C}$ -аар дулаарч байсан бол 1976-2006 оныг хүртэл 10 жил тутамд $0,52^{\circ}\text{C}$ -аар дулаарчээ. Иймээс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг илүү тодоор тайлбарлах өргөн цар хүрээтэй судалгаа хэрэгтэй байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлт халдварт өвчинтэй хэрхэн уялдаж байгааг судлах нь тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Арга зүй

Судалгааг Улаанбаатар хотын 1996-2016 онуудын сар бүрийн дундаж агаарын температурын үзүүлэлт, ХӨСҮТ БГХӨСҮТ-ийн архивийн 1996-2008 оныхалдварт өвчний эпидемиологийн судалгааны үр дүн болон үндэсний статистикийн газраас хийсэн хүн амын өсөлтийн судалгааны үзүүлэлт бүхий эх сурвалжуудыг үндэслэн ретроспектив төсөөллийн аргаар хийсэн болно.

Үр дүн

ДЭМБ, ХӨСҮТ, БГХӨСТ-ийн 2008 оны хамтарсан ретроспектив судалгааны дүнгээр монгол улс 1940-1975 оныг хүртэл 10 жил тутам $0,06^{\circ}\text{C}$ -аар дулаарч байсан бол 1976-2006 оныг хүртэл 10 жил тутамд $0,52^{\circ}\text{C}$ -аар дулаарчээ. Үндэсний статистикийн хүн амын тооллогын дүнгээр Монгол улсын хүн амын өсөлт 2010-2014 онд 2.20 хувь болж өссөн бол нийслэлийн хүн амын тоо 2010-2014 оны хооронд 3.3 хувиар өссөн байна. Халуун, хуурай өдрүүдийн тоо ихсэхэд халдварт өвчний гаралт даган өсөх хандлагатай байгааг ДЭМБ-ын гаргасан тоо баримт болон бусад орнуудад хийгдсэн судалгаа нотолж байна. Уур амьсгалын өөрчлөлттэй хүчтэй хамааралтай халдварт өвчинд холер, менингококкт халдвар; дунд зэргийн хамааралтай суулгалт халдвар, томуу, томуу төст өвчин; сул хамааралтай Лаймын өвчин зэрэг Монгол улсад бүртгэгдсэн халдварт өвчнүүд орж байна. Бидний тооцоолсноор хотжилт болон дэлхийн дулаарлын улмаас 2035 он гэхэд Монгол улсад халдварт өвчний дэгдэлт нэмэгдэх хандлагатай гарч байна. Халдварт өвчний өсөлтөнд орчны, нэн ялангуяа ус, хөрсний бохирдол чухал нөлөөлөл үзүүлэх нь тодорхой байна. 2014 оны байдлаар Монголын хүн амын 65% нь бохирдлын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй бөгөөд сайжруулсан ариун цэврийн байгууламжгүй нөхцөлд амьдарч байна. Нийслэлд манай улсын нийт хүн амын 50% амьдардаг нь хүн амын хэт төвлөрөл үүсгээд байгаа ба үүний 63% буюу 720 мянган хүн ам нь инженерийн дэд бүтцийн хангамжид холбогдоогүй гэр хороололд амьдарч ил задгай ариун цэврийн байгууламж ашиглаж байгаа. Агаарын дундаж температур сүүлийн 20 жилд $0,52^{\circ}\text{C}$ -аар өссөн нь дараагийн 20 жилд агаарын температур $0,98-1,04^{\circ}\text{C}$ хүртэл өсөх төлөвтэй гарч байна. Хүн амын төвлөрөл саарахгүй, ус, хөрсний бохирдол энэ янзаараа эрчтэй үргэлжилэх нөхцөлд цаг уурын дулааны эрс тэс байдал алдагдсанаас хүчтэй хамааралтай халдварт өвчин холер, менингококкт халдвар; дунд зэргийн хамааралтай суулгалт

халдвар, томуу; сул хамааралтай Лаймын өвчин зэрэг халдварт өвчний дэгдэлт, тархалт өсөх юм байна. Үүний нэг жишээ: улаанбурхан өвчин 2010-2014 онуудад Монгол улсад улаанбурханы өвчлөл бүртгэгдээгүй байсан ба 2015 оны гуравдугаар сарын 18-нд Нийслэлийн Баянзүрх дүүрэгт Улаанбурханы анхны тохиолдол мэдээлэгдсэн. Үүнээс хойш 2016 онд халдварт өвчний дэгдэлт дахин сэргэх хандлагатай байна.

Дүгнэлт: Халдварт өвчлөлийн тархалт, дэгдэлтийг бууруулахад орчны, тэр дундаа ус, хөрсний бохирдлыг багасгах чухал байна. Үүний шийдэл нь хүн амын төвлөрлийг сааруулах, гэр хорооллыг дахин төлөвлөлтөнд оруулж нэгдсэн инженер шугам сүлжээнд холбох, хог хаягдал болон бохир усны цэвэрлэх, боловсруулах төвлөрсөн өндөр хүчин чадалтай байгууламжуудыг барих, хүн амыг вакцинжуулалтанд тогтвортой хамруулах, хүн амын хувийн эрүүл мэндийн хамгаалал, эрүүл ахуйн мэдлэг дадлыг дээшлүүлэх явдал болно.

Түлхүүр үг: Хар тугалга, мах, ундны ус